



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Г Хорооны 49 дүгээр тогтоолд 7  
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын 1.3, 3.1 дэх хэсэг болон “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2012 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 17 дугаар тогтоол, мөн банкны гүйцэтгэх захирлын мөн өдрийн 2/149 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-иас гадаадын хөрөнгийн бирж дээр гаргах үнэт цаасыг бүртгэх тухай” 49 дүгээр тогтоолын 1 дэх заалтын “... 500,000,000 /таван зуун сая/...” гэснийг “... 580,000,000 /таван зуун наян сая/...” гэж өөрчилсүгэй.

2. Тогтоолд өөрчлөлтийг оруулж үнэт цаасны бүртгэлд 80,000,000 /наян сая/ америк долларын үнийн дүн бүхий бондыг нэмж бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН